



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/25

Амардалай

Газар эзэмших эрхийг  
шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Алтан загас-5 501 тоот)-д байршилтай иргэн Довдон овогтой Цэрэндэжид (ЗЮ55060162)-ын 500 м.кв (0.05 га) Шатахуун түгээх газар, агуулахын зориулалттай газрыг Загдхорол овогтой Түвшинтөр (ЗЕ92071510)-д өмнөх эзэмшигчийн газрын зориулалт, хугацаагаар буюу 8 жилээр үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/01 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ



482491043